



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrttd.gov.mn,  
Цахим хуудас: www.mrttd.gov.mn

ДОРН-04-03 № 11/1400

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “ТТЗ” ХХК,  
“ГТХЗНТ” УТҮГ, “МИАТ” ТӨХК, “ИНЕГ”,  
“АТҮТ” ТӨҮГ, “ЗТХТ” ТӨҮГ, “ДЗ” УТҮГ,  
НТОЗШША, “ХХНОБ” ТӨХХК-ИЙН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

**Журам аргачлалын хэрэгжилтийг  
хангаж ажиллах тухай**

Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/42, А/71 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал”, А/43, А/72 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам”-ыг тус тус хавсралтаар хүргүүлж байна. Журам аргачлалаар холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА

Б.БАТ-ӨЛЗИЙ



030002248



Боловруулса: *Ө.Монгол*

Хянасан: *[Signature]*

Хувь: .....

Огноо: 2024.04.03



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0027  
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,  
Цахим шуудан: pro@prokuror.mn,  
Цахим хуудас: www.prokuror.mn

2024.03.29 № 1/2827  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Журам, аргачлал хүргүүлэх  
тухай**

Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/42, А/71 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", А/43, А/72 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам"-ыг хүргүүлэв.


Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын хамтын нийгэмлэг (GIZ) хамтран "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийг бий болгохоор ажиллаж, системийн туршилтын ажиллагаа явагдаж байгаа ба 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэн, эрх бүхий байгууллагуудыг системд үе шаттай холбох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем дээрх аргачлал, журмын хэрэгжилтийг шууд тооцох бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.4 дэх заалтад заасны дагуу холбогдох мэдээллийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд "e-mongolia" системийг ашиглан хүргэх хөгжүүлэлт, холболтын ажил хийгдэж байна.

Иймд зөрчлийн хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт, дээрх аргачлал, журмын хэрэгжилтийг хангуулах, эрх бүхий албан тушаалтнуудыг сургаж, дадлагажуулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН  
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ШАДАР ЗӨВЛӨХ



М.ЧИНБАТ

1501031749

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

Эрх зөрчил төлөөлөгч  
актын улсын нэгдсэн бүртгэгч  
2024 оны 03 сарын 09-ны  
өдрийн 2.1 дугаарт бүртгэв.  
6727

2024 оны 03 дүгээр  
сарын 13 ны өдөр

Дугаар

*11/42, 11/71*

Улаанбаатар  
хот

**Аргачлал батлах тухай**


**Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн  
ТУШААХ нь:**

1."Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал"-ыг нэгдүгээр, холбогдох эрх зүйн хэлбэрийн загварыг хоёроос дөрөвдүгээр хавсралт ёсоор баталсугай.

2.Аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг прокурор, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга (Ц.Батболд), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Нямгэрэл) нарт тус тус даалгасугай.





## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААС ОНОГДУУЛСАН ТОРГОХ ШИЙТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ ТООЦОХ ХУГАЦАА, АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн тооцох, шийтгэл биелүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал" (цаашид аргачлал гэх)-ыг баримтална.

1.2. Энэхүү аргачлалд заасан торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн тооцох хугацааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлд заасан журмын дагуу тоолох ба нэмэгдүүлэн тооцсон хувь, хэмжээг "нэмэгдүүлэн тооцсон төлбөр" гэсэн нэршлээр ойлгоно.

1.3. Шийтгэл оногдуулсан шийдвэрийн биелэлтийг түр түдгэлзүүлсэн тохиолдолд шүүхээс оролцогчийн гаргасан гомдлыг шийдвэрлэх хүртэл хугацаа тоолохыг зогсооно.

1.4. Эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн бол шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн тооцохгүй.

1.5. Эрх бүхий албан тушаалтны торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцсон хувь хэмжээ, хугацаатай холбоотой гомдлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

### Хоёр. Торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хувь хэмжээ, хугацаа

2.1. Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан шийдвэрээ зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.4 дэх заалтад заасны дагуу мэдэгдсэн үеэс торгох шийтгэлийг биелүүлэх хуульд заасан хугацаа тоологдоно.

2.2. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд оногдуулсан торгох шийтгэлийн хэмжээг хугацаа хэтрүүлсэн сар бүр 10 хувиар нэмэгдүүлэн тооцно. Шийтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тооцох нийт хугацаа 5 сараас, нийт хувь хэмжээ нь торгох шийтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

2.3. Торгох шийтгэл, нэмэгдүүлсэн хувь хэмжээг энэ аргачлалд заасны дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.4 дэх заалтад заасны дагуу мэдэгдэл хүргэх системээр зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хүргэнэ.

2.4.Энэ аргачлалын 2.2-т заасан хугацаа дуусмагц эрх бүхий албан тушаалтан дараах шийдвэрийг гаргаж, харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ. Үүнд:

2.4.1.хуулийн этгээд нь оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг төлөөгүй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх хүсэлт;

2.4.2.хүнд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр нь 450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс доош бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх хүсэлт;

2.4.3.хүнд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр нь 450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш бол нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих санал.

2.5.Эрх бүхий албан тушаалтан аргачлалын 2.4 дүгээр зүйлийн 2.4.3-т заасан саналыг зөрчил үйлдсэн хүнд танилцуулж, оршин суугаа (оршин байгаа) газар, эсхүл тухайн зөрчил гаргасан харьяаллын шүүхэд хүний хамт хүргүүлнэ.

2.6.Зөрчил үйлдсэн хүн оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг аргачлалд заасан хугацаанд бүрэн төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй үлдсэн хэмжээнээс хамааран аргачлалын 2.4 дүгээр зүйлийн 2.4.2, 2.4.3-т заасан аль тохирох шийдвэрийг гаргана.


2.7.Зөрчил үйлдсэн хүн оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг аргачлалд заасан хугацаа дууссаны дараа төлсөн нь нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

### Гурав.Бусад

3.1.Эрх бүхий албан тушаалтан аргачлалын 2.4 дүгээр зүйлд заасан шийдвэрийг нэгдсэн бүртгэлд даруй бүртгэнэ.

3.2.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөр, түүний төлөлтийн талаарх баримт, аргачлалын 2.4 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан санал, хүсэлт болон шүүхийн шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг, материалд хавсаргана.

3.3.Энэ аргачлалыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮСЭЛТ**

..... оны ... дүгээр  
.....  
сарын ...-ний өдөр  
сум

хот,

..... ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

Шийдвэрийн биелэлтийг албадан  
гүйцэтгүүлэх тухай

.....  
*/Эрх бүхий байгууллага, албан тушаал, цол, нэр/ би,  
.....-д /зөрчил үйлдсэн хуулийн этгээдийн нэрийг бичих/ ...  
оны ... дугаар сарын ... -ний өдөр Зөрчлийн тухай хуулийн ... дүгээр зүйлийн ... хэсгийн ...  
дэх заалтад зааснаар ..... нэгж /хувь/-тэй тэнцэх хэмжээний буюу ..... төгрөгийн  
торгох шийтгэлийг ..... дугаартай шийтгэлийн хуудсаар оногдуулж, ... оны ...  
дугаар сарын ... -ний өдрийн дотор сайн дураар биелүүлэхийг даалгасан.*

..... */зөрчил үйлдсэн хуулийн этгээдийн нэрийг бичих/ нь  
оногдуулсан ..... төгрөгийн торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөр .....  
төгрөг, нийт ..... төгрөгийг төлөөгүй, торгох шийтгэлийг биелүүлэх хуульд заасан  
хугацааг ... оны ... сарын ... -ны өдрөөс ... оны ... сарын ... -ны өдөр хүртэл .....  
*/5 сараас дээш/ хугацаагаар хэтрүүлсэн нь ....**

..... баримтаар тогтоогдож байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, Зөрчил шалган  
шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага  
болгон ..... */зөрчил үйлдсэн хуулийн этгээдийн нэрийг  
бичих/-ээс оногдуулсан шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр  
..... төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан  
гүйцэтгүүлэх хүсэлтийг ..... шүүхэд гаргав.*


Хүсэлтэд шийтгэлийн хуудасны хуулбар, хаягийн лавлагаа зэрэг ... хуудас материал  
хавсаргасан болно.

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН: /...../ /...../

*/сарын үсэг/*

*/нэр/*



**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮСЭЛТ**

..... оны ... дүгээр  
.....  
сарын ...-ний өдөр  
сум

хот,

.....ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

Шийдвэрийн биелэлтийг албадан  
гүйцэтгүүлэх тухай

.....  
*Эрх бүхий байгууллага, албан тушаал, цол, нэр/ би, ..... овогтой*  
..... -д *Зөрчил үйлдсэн хүний овог, нэрийг бичих/* ... оны ... дугаар сарын  
... -ний өдөр Зөрчлийн тухай хуулийн ... дүгээр зүйлийн ... хэсгийн ... дэх заалтад зааснаар  
..... нэгж /хувь/-тэй тэнцэх хэмжээний буюу ..... төгрөгийн торгох шийтгэлийг  
..... дугаартай шийтгэлийн хуудсаар оногдуулж, ... оны ... дугаар сарын ... -ний  
өдрийн дотор сайн дураар биелүүлэхийг даалгасан.

..... *Зөрчил үйлдсэн хүний нэрийг бичих/* нь оногдуулсан  
..... төгрөгийн торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөр ..... төгрөг, нийт  
..... *450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс доош/* төгрөгийг төлөөгүй, торгох  
шийтгэлийг биелүүлэх хуульд заасан хугацааг ... оны ... сарын... -ны өдрөөс ... оны ... сарын  
... -ны өдөр хүртэл ..... *5 сараас дээш/* хугацаагаар хэтрүүлсэн нь  
.....  
..... баримтаар тогтоогдож байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ..... *Зөрчил үйлдсэн хүний нэрийг бичих/*-ээс оногдуулсан шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр ..... төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг ..... шүүхэд гаргав.

Хүсэлтэд шийтгэлийн хуудасны хуулбар, хаягийн лавлагаа зэрэг ... хуудас материал хавсаргасан болно.


ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН: /...../ /...../

/гарын үсэг/

/нэр/





**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ САНАЛ**

..... оны ... дүгээр сарын ...-ний өдөр сум

..... ХОТ,

.....ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

Торгох шийтгэлийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих тухай

..... /Эрх бүхий байгууллага, албан тушаал, цол, нэр/ би, ..... овогтой ..... -д /Зөрчил үйлдсэн хүний овог, нэрийг бичих/ .... оны .... дугаар сарын .... -ний өдөр Зөрчлийн тухай хуулийн ..... дүгээр зүйлийн .... хэсгийн .... дэх заалтад зааснаар ..... торгох шийтгэлийг..... дугаартай шийтгэлийн хуудсаар оногдуулж, .... оны .... дугаар сарын .... -ний өдрийн дотор сайн дураар биелүүлэхийг даалгасан.

..... /зөрчил үйлдсэн хүний нэрийг бичих/ нь оногдуулсан ..... төгрөгийн торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөр ..... төгрөг, нийт ..... /450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш/ төгрөгийг төлөөгүй, торгох шийтгэлийг биелүүлэх хуульд заасан хугацааг ..... оны ..... сарын .... -ны өдрөөс ..... оны ..... сарын .... -ны өдөр хүртэл ..... /5 сараас дээш/ хугацаагаар хэтрүүлсэн нь

.....б аримтаар тогтоогдож байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон .....-д /Зөрчил үйлдсэн хүний нэрийг бичих/ оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр ..... төгрөгийг ..... цагийн нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих саналыг ..... шүүхэд гаргав.

Саналд шийтгэлийн хуудасны хуулбар, хаягийн лавлагаа зэрэг .... хуудас материал хавсаргасан болно.

САНАЛ ГАРГАСАН  
ЭРХ БҮХИЙ АЛБАН  
ТУШААЛТАН:

/...../ /...../  
/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН: ЗӨРЧИЛ  
ҮЙЛДСЭН ХҮН

/...../ /...../  
/гарын үсэг/ /нэр/

Зөхиргээний мөн хэмжээ  
актын улсын нэгдсэн бүртгэл  
2024 оны 03 сарын 19-ны  
өдрийн 17.26 дугаарт бүртгэв.

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 03 дүгээр  
сарын 19-ны өдөр

Дугаар А/АЗ, И/ИД

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн  
**ТУШААХ нь:**

1. "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий  
байгууллага хооронд мэдээлэл солилцох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг прокурор, эрх бүхий  
байгууллагын алба хаагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын ерөнхий  
прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих  
хэлтсийн дарга (Ц.Батболд), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн  
бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Нямгэрэл) нарт тус тус  
даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,  
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ  
Б.ЖАРГАЛСАЙХАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД  
Б.О.ХУУЛ  
Б.О.ХУУЛ

Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, ЭРХ БҮХИЙ АЛБАН  
ТУШААЛТАН, ШҮҮХ БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА  
ХООРОНД МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцохтой холбоотой харилцаа болон дор дурдсан эрхийг хязгаарлах ажиллагааг зохицуулахад оршино. Үүнд:

1.1.1.зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг (цаашид торгох шийтгэл гэх) хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлах;

1.1.2.Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 (Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих), 11.19 дүгээр зүйлийн 10 (Татварын тухай хууль зөрчих), 14.4 дүгээр зүйлийн 3 (Автозамын тухай хууль зөрчих), 14.7 дугаар зүйл (Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих)-д заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг тус тус зохицуулна.

**Хоёр.Эрхийг хязгаарлах үндэслэл, ажиллагаа**

2.1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн мэдээллийг үндэслэн дараах эрхийг хязгаарлах ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1.торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрх;

2.1.2.торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал”-ын 2.2 дугаар зүйлд заасан хугацаанд төлөөгүй бол төлж дуусах хүртэл хугацаагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн;

2.2.Энэхүү журмын 2.1-д заасан тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлах ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагын эрх бүхий алба хаагч, бусад эрхийг хязгаарлах ажиллагааг цагдаагийн байгууллагын алба хаагч хэрэгжүүлнэ.

2.3.Цагдаагийн болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий алба хаагч нь тухайн хүн, хуулийн этгээд, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг шалгаж, торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлаж, энэ талаар "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан" (цаашид бүртгэл, мэдээллийн сан гэх)-д бүртгэнэ.

2.4.Цагдаагийн байгууллагын алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохицуулалтад хяналт, шалгалт хийх явцад энэхүү журмын 2.1 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан дор дурдсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлана. Үүнд:

2.4.1.торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг хууль, аргачлалаар тогтоосон хугацаанд төлөөгүй зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл;

2.4.2.бүртгэл, мэдээллийн санд торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг хууль, аргачлалаар тогтоосон хугацаанд төлөгдөөгүй төлөвт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл.

2.5.Энэхүү журмын 2.4 дүгээр зүйлийн 2.4.1-т заасан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахдаа тухайн тээврийн хэрэгсэл нь жолоочийн эзэмшил, өмчлөлийн тээврийн хэрэгсэл мөн эсэхийг заавал тогтоосон байна.

2.6.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахдаа аюулгүй ажиллагааг хангаж, холбогдох хууль, тогтоомжид заасан шаардлагыг хангасан тусгай талбайд хүргэх, эсхүл хууль тогтоомжид заасан бусад аргыг хэрэглэж болно.

2.7.Цагдаагийн байгууллагын алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааны өмнө тухайн тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгслийн жолооч, техникийн ажилтан, эсхүл тусгай талбай хариуцсан алба хаагчид тэмдэглэл үйлдэж, хүлээлгэн өгнө.

2.8.Үзлэг хийх явцад ачаа тээшинд түргэн муудаж чанараа алдах, хөлдөх хүнсний бүтээгдэхүүн болон эд зүйл байгаа тохиолдолд жолооч (эзэмшигч, өмчлөгч)-д тухайн эд зүйлсийг хүлээлгэн өгөх, хуулиар хориглосон ачаа бараа илэрсэн тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх арга хэмжээ авч, тэмдэглэлд тусгана.Үзлэгийн явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

2.9.Цагдаагийн байгууллагын алба хаагч нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан талаарх баримтыг жолоочид олгоно. Хэрэв жолооч нь баримт авахаас татгалзсан тохиолдолд энэ талаар тэмдэглэл үйлдэж, тухайн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан талаар материалд хавсаргана.

2.10.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд даруй бүртгэнэ.

2.11.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дор дурдсан тохиолдолд хязгаарлахыг хориглоно. Үүнд:

2.11.1.гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гамшгаас сэргийлэх, аврах, сэргээн босгох үйл ажиллагаа, эмнэлгийн түргэн тусламжид дуудлагаар явж байгаа;

2.11.2.замын хөдөлгөөнд оролцоогүй.

2.12.Цагдаагийн байгууллага нь тээврийн хэрэгслийг тусгай талбайд хүргэх, хадгалах, хамгаалах үүрэг гүйцэтгэж буй байгууллагын үйл ажиллагаа болон бусад аргаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавина.

2.13.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийг төлсөн даруйд энэхүү журамд заасан эрхийн хязгаарлалт дуусгавар болно.

2.14.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахтай холбогдон гарсан зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

### **Гурав.Эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох**

3.1.Эрх бүхий албан тушаалтан (Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, Татварын улсын байцаагч, Авто замын хяналтын улсын байцаагч) нь энэхүү журмын 1.1 дүгээр зүйлд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон хувь хэмжээ, төлбөр, түүний төлөлт, шийтгэл биелүүлэх ажиллагааны талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд тухай бүр, үнэн зөв байршуулна.

3.2.Цагдаагийн болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий алба хаагч тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн олгох, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эсэхийг шийдвэрлэхийн өмнө бүртгэл, мэдээллийн санд нэвтэрч, тухайн хүн, хуулийн этгээд, тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах эрхээр хангагдана.

3.3.Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх явцад бүртгэл, мэдээллийн санд нэвтэрч, тухайн хүн, хуулийн этгээд, тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах эрхээр хангагдана.

3.4.Эрх бүхий байгууллагын алба хаагч эрхийг хязгаарласан талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд нэн даруй бүртгэнэ.

3.5.Шүүх, прокурор эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

### **Дөрөв.Бусад**

4.1.Шүүх бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас энэхүү журамд заасан ажиллагаатай холбоотой мэдээллийг гаргуулан авч болно.

4.2. Прокурорын байгууллага бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

4.3. Журамд заасан эрхийг хязгаарлах ажиллагаатай холбоотой гомдлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

4.4. Эрх бүхий байгууллагын алба хаагч нь мэдээллийг албаны бус зориулалтаар ашиглах, хуулбарлах, бусдад дамжуулах, задруулахыг хориглоно.

4.5. Энэхүү журмыг зөрчсөн алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--